



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: ОРХОН АЙМАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ДЭД ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ОРА-2022/40-ШТА-ГА

Орхон аймаг
2022 он



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Ц.Нармандах
Утас:70353888 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Оргилмөрөн
Утас:703557955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn
Аудитор Г.Даваасүрэн
Утас:70350757 Цахим хаяг: davaasureng@audit.gov.mn
Аудитор Б.Азжаргал
Утас:70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn
Аудитор О.Хэрлэнзаяа
Утас:70357955 Цахим хаяг: kherlenzayao@audit.gov.mn
Аудитор Ж.Наранчимэг

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: orkhon@audit.gov.mn



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/15

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн "Эрх, үүрэг шилжүүлэх тухай" А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан "Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг"-ийн 1.1, 1.3 дахь хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орхон аймагт хэрэгжиж буй дэд хөтөлбөр, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Мөнхбат, аймгийн Засаг дарга С.Батжаргал нарт зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 2 дугаар улиралд гарган танилцуулахыг ахлах аудитор /Г.Оргилмөрөн/, аудитор /Б.Азжаргал, Г.Даваасүрэн, Ж.Наранчимэг, О.Хэрлэнзаяа/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудиторын 2022 оны 12
дугаар сарын 21-ний өдрийн А/15 дугаар
тушаалын хавсралт

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Алдаа зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын дугаар	Хариуцагч байгууллага	Мөнгөн дүн /мян.төгрөг/
1	2021 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлага, халалтыг зохион байгуулах зардлаас 419.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр илүү шилжүүлэн зарцуулсан, тус зардлыг онцгой комиссын зардлаас Боловсрол Шинжлэх Ухааны газарт олгосон санхүүжилт дээр нэмж тайлагнасан байна.	06/70ОРА-2022/40-ШТА-ГА	Санхүү төрийн сангийн хэлтэс	419.0
2	Оюутан цэрэг-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах арга хэмжээнд зарцуулсан зардлаас 1,752.0 мянган төгрөгийн анхан шатны баримтаар бүрэн дэмжигдэхгүй, тухайн арга хэмжээ нь зохион байгуулагдаагүй буюу санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслээгүй олгосон байна	07/71ОРА-2022/40-ШТА-ГА	Санхүү төрийн сангийн хэлтэс	1,752.0
3	Онцгой байдлын газрын онцгой комиссын зардлаас 2020-2021 онд худалдан авсан шатахуун талонд олгосон 9,677.6 мянган төгрөгийн урамшууллаас 1,554.5 мянган төгрөгийг дутааж, данс бүртгэлд тусгаагүй зарцуулсан байна.	08/72ОРА-2022/40-ШТА-ГА	Онцгой байдлын газар	1,554.5
4	Орхон аймгийн засаг даргын захирамжаар зарцуулсан 6 төсөл, хөтөлбөрийн 229,645.5 мянган төгрөгийн санхүүжилтийн анхан шатны баримтуудын бүрдлийг бүрэн хангуулаагүй байна.	07/116ОРА-2022/40-ШТА-ГА	Санхүү төрийн сангийн хэлтэс	239,645.5
5	Онцгой комиссын зардлын хэмнэлтээс 247,000.0 мянган төгрөгөөр аврах завь, усны мотоцикл худалдан авах ажиллагааг Онцгой байдлын газар 1 өдрийн дотор зохион байгуулж тус дүнгээр гэрээ байгуулж худалдан авсан байна.	08/117ОРА-2022/40-ШТА-ГА	Онцгой байдлын газар	247,000.0
6	Орхон аймгийн худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчийн мэдээллийн сантай гар утасны программ, 3-н хэмжээст цахим танилцуулга хийлгэх ажлаас 4,500.0 мянган төгрөгийн өртөгтэй программ нь хэрэгжээгүй байна.	09/118ОРА-2022/40-ШТА-ГА	Санхүү төрийн сангийн хэлтэс	4,500.0
7	"Эмч дэд хөтөлбөр"-ийн хүрээнд 2020, 2021 онуудад эмнэлгийн ажилтан, албан хаагчдад үзүүлсэн дэмжлэгийн хэмжээг 31,616.0 мянган төгрөгөөр илүү олгосон байна.	10/119ОРА-2022/40-ШТА-ГА	Нийгмийн бодлогын хэлтэс	31,616.0
Нийт дүн				526,487.0

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгт, дүрслэл, хавсралтын товъёг	2
Ерөнхий мэдээлэл	4
БҮЛЭГ 1. ДЭД ХӨТӨЛБӨРӨӨС БУСАД ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДЛЫГ БҮРЭН ҮНЭЛЭЭГҮЙ, ТӨСВИЙГ ХЭМНЭЛТТЭЙ, ҮР АШИГТАЙ, БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА	5
Дэд хөтөлбөрүүдийг тогтвортой хөгжлийн бодлого, аймгийг хөгжүүлэх зорилт, үйл ажиллагаа, үндсэн чиглэлд үндэслэн боловсруулсан байна	5
Дэд хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнг тооцоолсон боловч бусад төсөл хөтөлбөрийн хүрэх үр дүнг бүрэн тооцоогүй, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, бодитой төлөвлөөгүй байна 7	7
БҮЛЭГ 2. ДЭД БОЛОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫГ ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛААГҮЙ, ДОТООД ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА	11
Гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлийг үнэлж дүгнэсэн хэдий ч төсвийн арвилан хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг баримтлаагүй байна	11
Дэд хөтөлбөрийн хүрэх зорилтыг хангаж, үр дүнтэй хэрэгжсэн хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа ч санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна	13
Холбогдох байгууллагын санал:	17
ДҮГНЭЛТ:	19
ЗӨВЛӨМЖ:	19
ХАВСРАЛТУУД:	20

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ТББ	Төрийн бус байгууллага
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ШУТП	Шинжлэх ухаан, технологийн парк
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
ААН	Аж ахуйн нэгж
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс

Хүснэгт, дүрслэл, хавсралтын товьёг

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Дэд болон төсөл хөтөлбөрийн арга хэмжээний батлагдсан төсвийн мэдээлэл	9
Хүснэгт 2	2020, 2021 онд батлагдсан дэд болон төсөл хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зориулалтаар нь бүлэглэн харьцуулсан мэдээлэл	9
Хүснэгт 3	2018-2022 оны нийтийн тээврийн хөнгөлөлтөд олгосон зардлын мэдээлэл	14

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Орхон аймагт хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүд	5
График 2	Дэд болон төсөл хөтөлбөрийн тоо, төсвийн хувийн жин	8
График 3	Төсөл, хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл. /сая төгрөг/	11
График 4	Төсөл, хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл. /тоогоор/	11
График 5	Нийтийн тээврийн хөнгөлөлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл	14

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан дэд хөтөлбөрүүд	19
Хавсралт 2	Дэд болон төсөл хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний зардлын төсөв, гүйцэтгэл	20
Хавсралт 3	Дэд болон төсөл хөтөлбөрийн 2021 оны арга хэмжээний зардлын төсөв, гүйцэтгэл	28

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН МЭДЭГДЭЛ

Аудит хийх
үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Орхон аймагт хэрэгжүүлж буй дэд хөтөлбөр, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Дэд хөтөлбөр, төсөл хөтөлбөр болон зардлыг үндэслэлтэй, үр нөлөөтэй байхаар төлөвлөсөн эсэх
- Дэд хөтөлбөр, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөтэй хэрэгжсэн эсэх

Аудитын
хамарсан хүрээ

Аудитад Орхон аймагт 2020-2021 онуудад хэрэгжүүлэхээр баталсан дэд хөтөлбөр, төсөл хөтөлбөрүүд, аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 онуудын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-ын тогтоол хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, дэд болон төсөл хөтөлбөрүүдэд олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, холбогдох бусад баримт материалд үндэслэн, ИТХ, аймгийн Засаг даргын тамгын газар, тэдгээрийн харъя байгууллага, төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, дэд болон төсөл хөтөлбөр арга хэмжээг гүйцэтгэгч зарим аж ахуйн нэгж байгууллагын 2020-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, МУЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, тодруулга авч, шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын горимыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, ахлах аудитор В.Жавзмаа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оргилмөрөн, аудитор Б.Азжаргал, Г.Даваасүрэн, Ж.Наранчимэг, О.Хэрлэнзаяа нар 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 05-ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын
явцад учирсан
хүндрэл,
бэрхшээлүүд:

Аудитын явцад хүндрэл, бэрхшээл үүсээгүй болно.

Ерөнхий мэдээлэл

Аймгийн ИТХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны 15/03, 15/04 дүгээр тогтоолоор 2020 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар болон байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөрийн арга хэмжээг баталсан байна.

Энэхүү тогтоолд аймгийн ИТХ-ын 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 01 дүгээр, 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 16/03 дугаар, 2020 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 17/02 дугаар, 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор тус тус нэмэлт өөрчлөлт оруулж, тодотгон баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/05 дугаар тогтоолоор 2021 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар болон байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөрийн арга хэмжээг баталсан байна.

Уг тогтоолд аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дугаар сарын 17-ны өдрийн 07 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж, тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлуудаас бусад зардлыг төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалтын болон байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтад баталдаг байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган, төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийг Ор.Засаг дарга дансанд нэгтгэн, арга хэмжээ тус бүрээр хэрэгжүүлэн, зарцуулж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Орхон аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах болон холбогдох бодлогын баримт бичгүүдэд үндэслэн, аймгийн дэд хөтөлбөрүүдийг баталж, хөтөлбөрүүдэд тусгасан зорилтуудыг хангах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, ажилласан байна.

Дэд хөтөлбөр, төсөл хөтөлбөрийн зорилтыг хангах хүрээнд 2020 онд дэд хөтөлбөр, төсөл хөтөлбөрийн нийт 198 арга хэмжээнд 10,344.6 сая төгрөг, 2021 онд 177 арга хэмжээнд 10,588.9 сая төгрөг тус тус баталж, хэрэгжүүлсэн байна.


БҮЛЭГ 1. ДЭД ХӨТӨЛБӨРӨӨС БУСАД ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДЛЫГ БҮРЭН ҮНЭЛЭЭГҮЙ, ТӨСВИЙГ ХЭМНЭЛТТЭЙ, ҮР АШИГТАЙ, БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА

Дэд хөтөлбөрүүдийг тогтвортой хөгжлийн бодлого, аймгийг хөгжүүлэх зорилт, үйл ажиллагаа, үндсэн чиглэлд үндэслэн боловсруулсан байна

Орхон аймгийн хэмжээнд 2020, 2021 онд нийт 25 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласны 2 дэд хөтөлбөр нь 2017 оноос өмнө батлагдсан, 23 нь 2017-2020 онд тус тус баталсан байна.

Шинээр 2021 онд 4 дэд хөтөлбөр баталсны 2 нь төсөв хөрөнгө болон цаг хугацаанаас шалтгаалан 2021 ондоо хэрэгжиж эхлээгүй, 2 нь 2022 онд хэрэгжихээр байна. Мөн өмнөх 9 дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн, хэрэгжүүлж байна.

График №1



Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт №1

Эдгээр дэд хөтөлбөрүүдийг Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025”¹, Орхон аймгийн ИТХ-н 7 дахь удаагийн сонгуулийн Бүрэн эрхийн хугацааны бодлогын Үндсэн чиглэл², Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл³, аймгийн Засаг даргын 2016-2020⁴, 2020-2024⁵ оны үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн тус тус боловсруулжээ.

Үүнээс 2 дэд хөтөлбөрийг Улсын Их Хурлын, 5 дэд хөтөлбөрийг Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөр, төрөөс хэрэгжүүлэх бодлогын дагуу, боловсруулж баталсан байна.

Дэд хөтөлбөрүүд судалгаанд үндэслэсэн бол бусад төсөл хөтөлбөр нь урьдчилсан судалгаагүй байна

Аймгийн ЗДТГ нь хөрөнгө оруулалтаар хийгдэх дэд хөтөлбөр, төсөл хөтөлбөрийг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэл болон нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэн, төсвийн шууд захирагч нараас санал авч, боловсруулан, холбогдох хөтөлбөр зорилгуудтай нийцүүлэн ангилж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн байна.

¹ Аймгийн ИТХ-н 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 13/01 дүгээр тогтоол,

² Аймгийн ИТХ-н 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн Ээлжит II хуралдааны 01 дүгээр тогтоол,


³ Аймгийн ИТХ-н 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/01 дүгээр тогтоол,

⁴ Аймгийн ИТХ-н 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол,

⁵ Аймгийн ИТХ-н 2020 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/02 дугаар тогтоол.

Аймгийн ИТХ-аар батлагдсан дэд хөтөлбөрүүдийг тоон мэдээлэл, суурь үзүүлэлтэд тулгуурлан, нөхцөл байдлын үнэлгээ хийж, зорилго, зорилтыг тодорхойлсон байна. Тухайлбал:

Эмч болон Багш дэд хөтөлбөр



"Багш" дэд хөтөлбөрийг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Бүсчилсэн хөгжлийн бодлого, "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он), Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийн хөгжлийн цогц бодлого, Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, бүх шатны боловсролын багш, удирдах ажилтан, ахмад багш, эрдэмтдийн саналд үндэслэн боловсруулав.

Тус хөтөлбөрийг боловсролын салбарын багш, ажилтнуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр гэж ойлгоно.

Өнөөгийн байдал

Орхон аймгийн боловсролын салбарт ажиллаж байгаа багш нарын талаарх тоон үзүүлэлтийг товчхон мэдээлэл боловсон хүчний хувьд мэргэжлийн багшийн хангалт сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 98 хувь, ЕБС-д 98.4 хувьтай байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад удирдах ажилтан, багш, туслах багш 624, бусад ажилтан 411, ерөнхий боловсролын сургуульд багш, удирдах ажилтан 1125, бусад ажилтан 435 хүн ажиллаж байна. Эдгээрээс төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд -1008, цэцэрлэгт үндсэн - 300, туслах - 280 багш, Насан туршийн боловсрол олгох төвд 9, МСУТ, Их, дээд сургуульд 204 багш, цөлийн багш нийт 1781 багш ажиллаж байна. Нийт багшийн 88.0 хувь нь цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуульд ажилладаг. Үүнээс 22-39 насны багш 50.6 хувийг, 1-10 хүртэл жил ажиллаж буй залуу багш 45.2 хувийг тус тус эзэлж байгаа ба 2013 оноос 2017 оныг хүртэлх хугацаанд залуу багшийн тоо жилд дунджаар 2 хувиар нэмэгдсэн байна.

2013-2016 онуудад улсын болон орон нутгийн төсвөөр ерөнхий боловсролын 3 сургуулийн "Багш хөгжлийн төв"-ийг шинэчилсэн. Бусад сургуулиудад цөөн тооны суурин компьютертэй танхим эсвэл мэдээлэл зүйн кабинет, багшийн хөгжлийн төв нь нэг байдаг "Багш хөгжлийн төв"-үүд ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн бүх багш зөврийн компьютертэй болсноор цахим орчинд мэдлэг, боловсролоо дээшлүүлэх, хичээлийн явцад сургалтын хэрэгсэл болгон ашиглах, хичээл, үйл ажиллагаагаа бэлтгэх зэрэгт ахиц гарсан.

2017 оны 01-р сард авсан судалгаагаар ерөнхий боловсрол, цэцэрлэгийн багшийн 16,6 хувь нь өндөр өртөгтэй орон сууц түрээслэдэг, харин цэцэрлэгийн багш нарын 43,9 хувь, ЕБС-ийн багш нарын 21,7 хувь нь төвлөрсөн халаалттай орон сууцнаас бусад сууцанд амьдарч байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

"Багш" дэд хөтөлбөрийн (цаашид "хөтөлбөр" гэх) зорилго нь салбарын багш, ажилтны хөгжлийг дэмжих, таатай нөхцөл бүрдүүлэх, тэдний нэр хүнд, нийгмийн баталгааг



Орхон аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.1-д "Эмч" дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн.

Энэхүү зорилтын хүрээнд эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг чадвар, өс зүйн төлөвшилийг сайжруулах, гадаад харилцааг нээлттэй түвшинд хүргэх, нийгмийн асуудлыг дэмжих, шинэ технологи арга барилыг орон нутагт нутагшуулах, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах үүднээс энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

Хүн амын тоо өдөр ирэх тусам өсөн нэмэгдэх хандлагатай байгаа нь тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд үйлчлэх үйлчилгээний орчин үеийн арга барил нэвтрүүлэх, орчин үеийн шинэ тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, нутагшуулах, орон нутагтаа сургалтын бааз эмнэлэгтэй болж, дотоод болоод гадаадын мэргэшсэн багш, мэргэжилтнээр ажлын байран дээрх сургалтыг тасралтгүй явуулан үр чадавтай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтан бэлдэх, тэдний нийгмийн асуудлыг шийдэх, материаллаг баазыг бэхжүүлж, ажиллах нөхцлийг сайжруулах шаардлага зүй ёсоор гарч ирж байна.

Дээрх асуудлыг бодитой шийдвэрлэхэд нэг талаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авч буй үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлага, эмч, эмнэлгийн ажилтны хөгжлийн чиг хандлага, нөгөө талаас төр захиргааны байгууллага, олон нийтийн зүгээс эмчэмнэлгийн ажилтныг дэмжих үйл ажиллагааны зохиистой тэнцлийг хангах бодлого боловсруулах шаардлага нь хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

Хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль¹, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030², Эрүүл мэндийн тухай хууль³, Монгол улсын төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого⁴, Орхон аймгийн хөгжлийн цогц бодлого⁵, Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр⁶ Хөгжлийн бодлогын баримт⁷ бичиг боловсруулах нийтлэг журам зэрэг бодлогын бичиг баримтуудыг үндэс болгов.

Хоёр. Өнөөгийн байдал

Орхон аймгийн хэмжээнд 101897 хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Медипас эмнэлэг, Жаргалант сумын эрүүл мэндийн төв, 9 өрхийн эрүүл мэндийн төв, Эмнэлэг сувилагын цогцолбор, Хувийн хэвшлийн ортой 11 эмнэлэг, үүдэнд 48 эмнэлэг, эм ханган нийлүүлэх 8 байгууллага, 52 эмийн сан зэрэг эрүүл мэндийн 136 нэгжид их эмч 325 буюу 21.3 хувь, сувилагч тусгай мэргэжилтэн 418 буюу 27.4 хувь, эмнэлгийн техникийн боловсролтой ажилтан 261 буюу 17.1 хувь тус салбарт нийт 1522 хүн хүргэн ажиллаж байна. Нийт эрүүл мэндийн ажилтнуудын⁸ 8,3 хувь нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагад, 33.3 хувь нь хоёр дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байна.

2015 оны байдлаар 10 000 хүн амд ноогдох их эмчийн хангалт улсын дундаж 31.6, аймгуудын дундаж 22.3 байна. Орхон аймаг 2015 онд 10 000 хүн амд ноогдох их эмчийн 27.4

Дэд хөтөлбөрөөс бусад төсөл хөтөлбөрүүдэд судалгаа, тооцоолол хийсэн баримт материал байхгүй, холбогдох хэлтсүүдийн боловсруулсан санал, аймгийн хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ, өмнөх оны гүйцэтгэл, цаг үеийн бодлого, үйл ажиллагаатай уялдан төлөвлөгдсөн байна.

Төсөл, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг бүрэн үнэлээгүй байна

Орон нутгийн 2020, 2021 онуудын хөрөнгө оруулалтын жагсаалтад багтсан төсөл арга хэмжээ нь нийгмийн зорилтот бүлэг, байгаль хамгаалах, нийтийн тээвэр, хууль сурталчлах, дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

Бодит тооцоо судалгаа багатай, ач холбогдлыг үнэлж тусгаагүй, орон нутгийн иргэдэд төдийлөн үр дүнтэй биш дараах арга хэмжээнүүдийг баталсан байна.

- Орхон аймгийн Срайдорж номун хааны 8-р дүрийн хувилгаан Лувсандамбийжанцанд Бат-Оршил өргөх ёслол зохион байгуулах /2020/
- Булган аймагтай хамтран ажиллах /2020/
- Дотоодын болон гадаадын орнуудад зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэн яармаг, бизнес форумд орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжин оролцуулах – хасагдсан⁶
- "Эрдэнэтийн өдрүүд" арга хэмжээг гадаадын найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай хотуудад зохион байгуулах /2020/

⁶ Аймгийн ИТХ-н 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Ээлжит бус I хуралдааны 01 дугаар тогтоол.

- Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль болон холбогдох хууль, журам, дүрмийн хэрэгжилтийг хангах, сургалт зохион байгуулах /2020/
- Баг тус бүрийн иргэдийн оролцоог дэмжих зардал – Орон нутгийн сонгуулийн сурталчилгаатай холбоотой /2020/
- Барилгын салбарын ажиллагсдын ур чадварыг сайжруулах сургалт, зөвлөгөөн, өдөрлөг зохион байгуулах /2020, 2021/
- Бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох үйл ажиллагааны зардал /2020, 2021/
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын ажилд шинэ техник, технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд ажиллагсдыг чадавхжуулах ажлыг зохион байгуулах /2020,2021/
- Жилийн турш төрийн албан хаагчдыг сургаж чадавхжуулах зардал /2021/
- Хуулийн байгууллагуудын ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, туршлага судлах ажлыг зохион байгуулах /2020, 2021/
- Шүүхийн зардал /Улсын тэмдэгтийн хураамж, Өмгөөлөгчийн болон шинжээчийн хөлс төлсөн, 2020-2021 он/
- “Орхон аймаг, Эрдэнэт хотын ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025” бодлогын баримт бичгийг орон нутагт хэрэгжүүлэх /2020, 2021/
- Орон нутгийн төсвөөс Улаан загалмайн хороонд олгох дэмжлэгийн зардал /2021/
- "Эрдэнэт" цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны үйл ажиллагааны зардал /2020,2021/
- Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж урамшуулах.
- “Эрүүл мэнд нийгмийн даатгалын төлөөлөгч” төсөл хөтөлбөрийн зардал

Эдгээр төсөл арга хэмжээ нь тэвчиж болох, ач холбогдолгүй, холбогдох байгууллагын үйл ажиллагаа, зарим хөтөлбөр арга хэмжээтэй давхардсан нь төсвийн үр ашгийг бууруулж байна.

Дэд хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнг тооцоолсон боловч бусад төсөл хөтөлбөрийн хүрэх үр дүнг бүрэн тооцоогүй, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, бодитой төлөвлөөгүй байна

Аймаг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан дэд хөтөлбөрүүдийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон боловч зарим дэд хөтөлбөрүүдийн үр дүнгийн шалгуурыг тоо, чанарын үзүүлэлтээр тодорхойлоогүй байна. Тухайлбал: Анхдагч дэд хөтөлбөр, Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай дэд хөтөлбөр, Өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр, аймгийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилсан сэргийлэх дэд хөтөлбөр.

Харин аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд боловсруулан, шинэчлэн баталсан 9 дэд хөтөлбөрийн /хавсралт №1/ хүрэх үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлжээ.


УИХ-аас баталсан “Ус” үндэсний хөтөлбөр, “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ыг УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоолоор, Засгийн газрын тогтоолоор 2017 онд батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”, “Үндэсний хөтөлбөр батлах тухай”, 2019 онд батлагдсан “Үндэсний хөтөлбөр батлах тухай” тогтоолуудыг Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор тус тус хүчингүй болгосон байна. Иймд дээрх тогтоол, үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд баталсан аймгийн дэд хөтөлбөрүүдийг хүчингүй болгох, шинэчлэх нь зүйтэй байна.

Төсвийн тухай хуулийн 4.1.16-д төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг “хөтөлбөр” гэж, 4.1.17-д хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ,

цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг "арга хэмжээ" гэж тус тус тодорхойлсон байдаг.

Гэтэл дэд хөтөлбөрүүдээс бусад төсөл хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнг тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тооцож батлаагүй бөгөөд нийт хөтөлбөр, арга хэмжээний тоо, дүнгийн дийлэнх хувийг энэхүү төсөл хөтөлбөрүүд эзэлж байна.

График №2



Өөрөөр хэлбэл нийт хөтөлбөр, арга хэмжээнээс дэд хөтөлбөр буюу 10 хүрэхгүй хувьд нь хүрэх үр дүн, тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

Үр дүн гарсан, хангалттай үнэлэгдсэн дэд хөтөлбөрүүдийг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан шинэчлэн баталж, үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн байна.

Иймд дэд хөтөлбөрүүдээс бусад төсөл хөтөлбөрүүдийг ач холбогдол, хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд үндэслэн төлөвлөх, батлах шаардлагатай байна.

Өөр хоорондоо уялдаагүй арга хэмжээг хөтөлбөрт тусгаагүй байна

Орон нутгийн хөрөнгө оруулалтын болон байгаль хамгаалах сангийн жагсаалтад төсөл, хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг дараах байдлаар баталжээ.

Дэд болон төсөл хөтөлбөрийн батлагдсан төсөв

Хүснэгт №1		сая төгрөг			
Д/д	Эх үүсвэр	2020		2021	
		Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орон нутгийн хөрөнгө оруулалт	178	9,540.6	141	10,091.4
2	Байгал хамгаалах сан	20	804.4	36	497.5
Дүн		198	10,344.6	177	10,588.9

Батлагдсан төсөв, хөтөлбөр арга хэмжээ нь Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг хөгжүүлэх үндсэн чиглэл, дэд хөтөлбөрүүд, аймаг бие даан хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд зориулагдсан байна.

Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, бодитой төлөвлөхөд ач холбогдол өгөх шаардлагатай байна

Аймгийн ИТХ-н 2019 оны 15/03 дугаар тогтоолоор 2020 онд хэрэгжүүлэх 192 төсөл хөтөлбөрт 9,955.0 сая төгрөг, 2020 оны 02/05 дугаар тогтоолоор 178 төсөл хөтөлбөрт 8,287.5 сая төгрөгийн хөрөнгө баталсан байна.

Харин төсвийн жилийн явцад орсон тодотгол, нэмэлт өөрчлөлтөөр эцэслэн батлагдсан төсвийг хэрэгжүүлэх арга хэмжээ, чиг үүрэг, зорилтот бүлэг, зориулалт зэргийг харгалзан ангилан харуулбал дараах байдалтай байна.

2020, 2021 онд батлагдсан дэд болон төсөл хөтөлбөр (хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зориулалтаар нь бүлэглэсэн)

Хүснэгт №2

сая төгрөг

Д/д	Төсөл, арга хэмжээ бүлэглэсэн байдлаар	2020	Дүнд эзлэх хувь	2021	Дүнд эзлэх хувь	Өмнөх оноос өсөлт, (-бууралт)		Өөрч лөл тын хувь
						Дүн	Хувь	
1	Дэд хөтөлбөр	1,411.5	13.6%	840.0	7.9%	-571.5	-40.5%	-5.5%
2	Төрийн албан хаагчдад чиглэсэн	125.0	1.2%	150.5	1.4%	25.5	20.4%	0.2%
3	Хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагаа таниулан сурталчилах	81.5	0.8%	97.2	0.9%	15.7	19.2%	0.2%
4	Онцгой байдал	922.0	8.9%	2,552.0	24.1%	1,630.0	176.8%	15.8%
5	Хяналт шинжилгээ	75.8	0.7%	33.4	0.3%	-42.4	-56.0%	-0.4%
6	Цагдаа, хуулийн байгууллагад	386.8	3.7%	376.0	3.6%	-10.8	-2.8%	-0.1%
7	Үйл ажиллагааны зардал /гэрээт/	1,173.0	11.3%	1,297.1	12.2%	124.1	10.6%	1.2%
8	Халамж	360.3	3.5%	304.0	2.9%	-56.3	-15.6%	-0.5%
9	Спорт, боловсрол	416.0	4.0%	418.0	3.9%	2.0	0.5%	0.0%
10	Ахмад настанд чиглэсэн	324.8	3.1%	260.2	2.5%	-64.6	-19.9%	-0.6%
11	Эрүүл мэндийн байгууллага, иргэний эрүүл мэнд	501.4	4.8%	170.0	1.6%	-331.4	-66.1%	-3.2%
12	Нийтийн авто тээвэр	1,446.7	14.0%	1,520.7	14.4%	74.0	5.1%	0.7%
13	Татварын байгууллагад	30.0	0.3%	39.3	0.4%	9.3	31.0%	0.1%
14	Цэргийн штаб	225.6	2.2%	135.2	1.3%	-90.4	-40.1%	-0.9%
15	Хэвлэл мэдээлэл	350.0	3.4%	250.0	2.4%	-100.0	-28.6%	-1.0%
16	Багт чигэлсэн	360.0	3.5%	0.0	0.0%	-360.0	-100.0%	-3.5%
17	Усны хөнгөлөлт, үйлчилгээ	495.0	4.8%	300.0	2.8%	-195.0	-39.4%	-1.9%
18	Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээ	879.0	8.5%	497.5	4.7%	-381.5	-43.4%	-3.7%
19	Шагнал, урамшуулал	110.0	1.1%	60.0	0.6%	-50.0	-45.5%	-0.5%
20	Хамтын ажиллагаа, сургалт, зөвлөгөөн	262.5	2.5%	420.2	4.0%	157.7	60.1%	1.5%
21	Тооллого	137.8	1.3%	52.6	0.5%	-85.1	-61.8%	-0.8%
22	Шашин	80.0	0.8%	30.0	0.3%	-50.0	-62.5%	-0.5%
23	Махны үнийн хөнгөлөлт	150.0	1.5%	400.0	3.8%	250.0	166.7%	2.4%
24	Тэмдэглэлт ой	40.0	0.4%	385.0	3.6%	345.0	862.5%	3.3%
ДҮН		10,344.6	100%	10,588.9	100%	244.3	730.8%	2.4%

Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт №2, №3

Ковид 19 цар тахалтай холбоотойгоор онцгой комиссын зардлыг 2021 онд 1,630.0 сая төгрөг буюу өмнөх оноос 176.8 хувиар, ой тэмдэглэхтэй холбоотой зардлыг 345.0 сая төгрөг буюу 862.5 хувиар, махны үнийн хөнгөлөлт, хамтын ажиллагаа, сургалт, зөвлөгөөн, үйл ажиллагаатай холбоотой 8 бүлэг зардлыг 658.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, өмнөх оны төсвийг нийт 2,633.2 сая төгрөгөөр буюу 25.5 хувиар нэмэгдүүлсэн бол,

Дэд хөтөлбөрийн зардлыг 571.5 сая төгрөг буюу өмнөх оноос 40.5 хувиар, багт чиглэсэн /нийт 24 багийн иргэдийн оролцоог дэмжих/ зардлыг 2021 онд дахин батлаагүй буюу 360.0 сая төгрөгөөр, байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 381.5 сая төгрөг буюу 43.4 хувиар, эрүүл мэндийн байгууллага, иргэний эрүүл мэнд, ахмад настанд

чиглэсэн, тооллого, шашин зэрэг 11 бүлэг зардлыг 1,076.0 сая төгрөгөөр бууруулж, өмнөх оны төсвийг нийт 2,389.0 сая төгрөгөөр буюу 23.1 хувиар бууруулсан байна.

Дээрх өсөлт, бууралтын нөлөөллөөр 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний тоо 2020 оноос 21 арга хэмжээгээр буурсан боловч батлагдсан төсөл хөтөлбөрийн зардлын дүн 244.3 сая төгрөг буюу 2.4 хувиар өссөн байна.

Нийт арга хэмжээнээс 2020 онд 284.6 сая төгрөгийн 20, 2021 онд 596.6 сая төгрөгийн 22 арга хэмжээний гүйцэтгэл огт гараагүй, тухайн арга хэмжээний зардлыг бүрэн хэмнэсэн, 2020, 2021 онд 548.5 сая төгрөгийн 19 арга хэмжээ 50 хүртэл хувийн гүйцэтгэлтэй байгаа нь зардлын төлөвлөлтийн тооцоо, судалгаа, үндэслэлийг сайжруулах шаардлагатай байна.

Үр нөлөө, ач холбогдол бага, тэвчиж болохуйц 17 асуудлын давхардсан тоогоор 47 арга хэмжээнд 1,058.6 сая төгрөг төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарчмын дагуу төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, бодитой төлөвлөхөд онцгой анхаарах шаардлагатай байна.

**БҮЛЭГ 2. ДЭД БОЛОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫГ ҮР ДҮНТЭЙ
ЗАРЦУУЛААГҮЙ, ДОТООД ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА**

Гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлийг үнэлж дүгнэсэн хэдий ч төсвийн арвилан хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг баримтлаагүй байна

Дэд хөтөлбөр болон төсөл хөтөлбөрийн арга хэмжээ нь хэрэгжүүлэх чиглэл, зориулалтаасаа шалтгаалан санхүүгийн олон төрөл, арга хэрэгслээр хэрэгжсэн байна. 2020 онд төлөвлөсөн нийт 198 арга хэмжээнээс 178 арга хэмжээнд 9,117.2 сая төгрөг, 2021 онд төлөвлөсөн 177 арга хэмжээнээс 155 арга хэмжээнд 9,484.1 сая төгрөг зарцуулсан байна.

График №3





График №4



Харин 2020, 2021 онд зохион байгуулаагүй, гүйцэтгэл гараагүй арга хэмжээнүүдийн зарим нь коронавируст халдвар цар тахлаас шалтгаалсан хязгаарлалт хориглолттой холбоотой байна.

Аймгийн ИТХ-аар батлагдсан хөтөлбөрүүдэд жил бүр, зохион байгуулах арга хэмжээний хүрээнд тодорхой төсөв батлагдан хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү төсөв нь батлагдсан хөтөлбөрийнхөө зорилтот арга хэмжээнд зарцуулагдаж байна.

Төсөл хөтөлбөрийн арга хэмжээнд баталсан нийт төсвөөс дэд хөтөлбөрт зарцуулсан зардал нь 2020 онд 14.5 хувийг, 2021 онд 8.3 хувийг эзэлж байна.

Төсөл арга хэмжээ тус бүрийн зардлын гүйцэтгэлийг хавсралт № 2, 3-аас үзнэ үү.

Төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна

Төсөл хөтөлбөрийг зохион байгуулахдаа аймгийн Засаг даргын захирамжаар төсөв зарцуулах эрх олгож, зардлын тооцоог хавсралтаар батласан байна. Захирамжийн хавсралтаар баталсан зардлын тооцоог боловсруулахдаа төсвийн арвилан хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг баримтлах, төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулах, гүйцэтгэлийн баримтыг үнэн зөв, бүрэн гүйцэт бүрдүүлэх талаар онцгой анхаарах шаардлагатай байна.

Төсөл, хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл, санхүүжилт, зарцуулалттай холбоотой дараах алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2020 оны А/473 дугаар захирамжаар "Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа алба хаагчдын хувцас хэрэглэл, сургалтын болон үүрэг гүйцэтгэх зардал" арга хэмжээний төсвөөс "Дайчилгаатай команд штабын хээрийн сургууль" арга хэмжээ зохион байгуулахад зарцуулсан 8.8 сая төгрөгийн зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх, анхдагч илгээлтийн эздэд дэмжлэг үзүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2020 оны А/709 дүгээр захирамжаар "Анхдагч" дэд хөтөлбөрөөс 2.0 сая төгрөгийг зарцаалсан боловч тайлангийн баримт дутуу, зориулалт бус, зарим зардлын зарцуулалт нь тодорхойгүй байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/684 дүгээр захирамжаар Хот тохижуулах газрын 225 ажилчдад ХАБЭА сургалт зохион байгуулахаар "ХЭМАББО эрдэм шинжилгээ, сургалт судалгааны төв" ТББ-д олгосон 20.0 сая төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

"Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн хүрээнд "Эрдэнэтийн эмч" ТББ-тай хамтран ажиллаж 37.7 сая төгрөгийг зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, дутуу баримтаар гүйлгээ хийсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 6/02 дугаар тогтоолоор "Багш" дэд хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу 2020, 2021 онуудад Боловсролын салбарын 12 менежерт 11.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхдээ заавал бүрдүүлэх материалын бүрдэл хангаагүй олгосон байна.

Багийн иргэдийн оролцоог дэмжих арга хэмжээний зардалд зарцуулсан 160.1 сая төгрөгийн анхан шатны баримт дутуу, зарцуулалтын тайлан баримт байхгүй байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/718 дугаар захирамжаар онцгой комиссын зардлын хэмнэлтээс шийдвэрлэсэн 247.0 сая төгрөгөөр аврах завь, усны мотоцикл худалдан авах ажиллагааг Онцгой байдлын газар 1 өдрийн дотор зохион байгуулж, Эрчимт цамхаг ХХК-тай гэрээ байгуулж худалдан авсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 6/04 дүгээр тогтоолоор "Эмч" дэд хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/628 дугаар захирамжаар баталсан Боловсрол, Эрүүл мэндийн салбарын ажилтнуудад дэмжлэг үзүүлэх журмаар тодорхойлсон дэмжлэгийн хэмжээг хэтрүүлэн 2020, 2021 онуудад 130 эмч, эмнэлгийн ажилтан, албан хаагчдад 31.6 сая төгрөг илүү олгосон байна.

Онцгой комиссын зардлаас 2020, 2021 онд худалдан авсан шатахуун талонд олгосон 9.7 сая төгрөгийн урамшууллаас 1.6 сая төгрөгийг дутааж, данс бүртгэлд тусгаагүй зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/274 дүгээр захирамжаар онцгой комиссын зардлаас шаардлагатай нөөц бүрдүүлэх, бодис, бараа материал худалдан авахад зориулж 31.7 сая төгрөгийг шийдвэрлэсэн байна. Уг хөрөнгийг АЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан Улаан загалмайн хорооны Онцгой байдлын газартай шууд гэрээ байгуулан нийлүүлсэн барааны төлбөрт олгожээ. Нийлүүлсэн зарим бараа чухал хэрэгцээ багатай, төсвийг үр ашиггүй зарцуулсан.

Багш, эмч дэд хөтөлбөрийн төсвийн зарцуулалтыг аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/628 дугаар захирамжаар батлагдсан "Журам баталж, зөвлөл байгуулах тухай" журамд тодорхойлсон шаардлагаа мөрдөж ажиллаагүйгээс баримтын бүрдэл хангагдахгүй байх, нэг хүнд олгох дэмжлэгийн хэмжээг хэтрүүлэн олгох зэрэг зөрчил гарсан тул энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулж шийдвэрлэх нь зүйтэй байна.

Дэд болон төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгээгүй байна

Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу дотоод хяналтыг Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг.

Санхүүгийн хяналт, аудитын албыг Сангийн яамнаас стандарт, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаагаа Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ын хүрээнд явуулдаг.

Орхон аймгийн СХАА нь жил бүрийн хяналт шалгалтын төлөвлөгөөгөө боловсруулж аймгийн Засаг дарга, дотоод аудитын хорооны даргаар батлуулан хэрэгжүүлдэг бөгөөд дэд хөтөлбөр, төсөл хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлд дотоод хяналт, шалгалт хийгээгүй байна.

Иймд Орхон аймаг хэрэгжиж буй дэд болон төсөл хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлд дотоод хяналт, шалгалт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зардлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, аудитаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгах үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна

Аймгийн Засаг даргын захирамжаар болон гэрээгээр гүйцэтгүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, зардлын гүйцэтгэл, баримтыг аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс, албад хүлээн авч, хянаж, үр дүнг тайлагнах чиг үүрэгтэй байдаг.

Жил бүрийн санхүүгийн тайлангийн аудитаар болон 2020 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн анхан шатны баримтгүй, баримтыг нөхөн бүрдүүлдэг, хугацаанд нь ирүүлдэггүй, зарцуулалтын болон гүйцэтгэлийн тайланд тухайн арга хэмжээнд хамааралгүй баримтыг дахин хавсаргадаг, давхардуулдаг, давхар шилжүүлдэг, батлагдсан төсвөөс илүү зардал гаргадаг, нотлох баримтын үнэн зөв байдал итгэл үнэмшил төрүүлэхүйц бус зэрэг зөрчлүүд давтагдан гарсаар байна.

Мөн аймгийн ЗДТГ, Орхон Засаг дарга сангийн төлбөрийн хүсэлтэд 1-р гарын үсэг зурагдаагүй, тамга дарагдаагүй болон гарын үсгийн дардас ашигласан, гүйлгээ хийсэн төрийн сангийн мэргэжилтэн баталгаажуулаагүй, төлбөрийн хүсэлтийн хяналтын хуудасны үндэслэх баримт бичгийг бүрэн хангуулаагүй, алдаатай бэлтгэсэн баримтаар гүйлгээ хийсэн зөрчлүүд илэрлээ.

Эдгээр нь төсөл хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий хэлтэс, албад, тэдгээрийн хариуцсан мэргэжилтнүүдийн уг арга хэмжээний чанар, гүйцэтгэл, зардлын зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, тавьсан шаардлагын хэрэгжүүлэлт сул, хариуцлага алдагдаж байгаатай холбоотой байна.

Дэд хөтөлбөрийн хүрэх зорилтыг хангаж, үр дүнтэй хэрэгжсэн хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа ч санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна

Төсөл, хөтөлбөрүүдийн урьдчилгаа санхүүжилтийг харилцан адилгүй буюу 50-80 хувиар, гүйцэтгэлийн баримтыг хүлээн авч үлдэгдэл 20-50 хувийг олгосон байна.

Тухайлсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд олон нийтэд мэдээлэл хүргэх, хэвлэл мэдээллийн байгууллагаар ажил гүйцэтгүүлэхдээ тухайн арга хэмжээний зардлаас хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан зарцуулж байна. Үүнд: Эрдэнэтийн өдрүүд арга хэмжээ, Он угтах үйл ажиллагаа, Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, Шилэн дансны мэдээ мэдээлэл хүргэх зэрэг нэвтрүүлэг, контент үйл ажиллагаа байна.

Харин “хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах төлөвлөгөөт ажил” арга хэмжээний зардлыг жил бүр тусад нь баталж, уг төсвөөс хэрэгжүүлэх ажил үйлчилгээг гэрээнд тодорхойлоогүй, тогтоосон тариф, ажлын тоо

хэмжээгүй, харилцан адилгүй үнийн дүнгээр хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан зардал гаргаж, гүйцэтгэлийг бодитой, үндэслэлтэй дүгнэж олгоогүй байна.

Санхүүжилт олгосон хэвлэл мэдээллийн байгууллага, сонин, сайтын гүйцэтгэлийг тэдгээрээс ирүүлсэн жагсаалтыг үндэслэж гэрээг хангалттайгаар үнэлсэн байна.


Гүйцэтгэлээр гаргаж өгсөн жагсаалт нь тус хэвлэл мэдээллийн байгууллага, сонин, сайтад байршуулсан мэдээ, мэдээллийн холбоос бөгөөд энэ нь тоо хэмжээ, чанар, мэдээллийн агуулга, цар хүрээ, хандалт, хүртээмж зэрэг хэмжигдэхүүнээр гэрээний үнийн дүнтэй хэрхэн уялдаж, тооцогдож байгаа нь тодорхойгүй байна.

Төсөл хөтөлбөрийн жагсаалтад нийтийн тээврийн хөнгөлөлтөд 2020, 2021 онд тус бүр 1,200.0 сая төгрөг баталсан байна. Эдгээр нь Дээд боловсрол, Мэргэжлийн боловсрол, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал, Ахмад настны хөгжил хамгаалал чиглэлээр зарцуулагдахаар батлагдсан байна.

2018-2022 оны нийтийн тээврийн хөнгөлөлтөд олгосон зардал

Хүснэгт №3	сая.төгрөг			
Үзүүлэлт	2018	2019	2020	2021
Төлөвлөгөө	845.9	845.9	1,200.0	1,200.0
Гүйцэтгэл	840.5	845.8	1,127.9	1,125.1

График №5



Нийтийн тээврийн хөнгөлөлтөд зарцуулж буй төсөв 2020 оноос 40.4 хувиар нэмэгджээ. Гүйцэтгэлийн санхүүжилтийг үйлчлүүлсэн зорилтот бүлэг дэх иргэний тоогоор бус шугамд үйлчилсэн автобусны ажилласан цагаар буюу төлөвлөсөн зардлын хэмжээнд гүйцэтгэл гарч, олгогдсон байна.

Дээд болон мэргэжлийн боловсролын оюутнуудад холбогдох хууль⁷, аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан журам⁸-д заасны дагуу нийтийн тээврийн хөнгөлөлтөд зориулж жилд 400.0 сая төгрөг баталсан боловч оюутнууд нийтийн тээврээр хөнгөлөлттэй үнээр зорчдоггүй, нийтийн тээврийн хөнгөлөлтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгодоггүй, нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч компаниудад татаас, дэмжлэг хэлбэртэй санхүүжилт олгогдсон байна.

Аймгийн ИТХ-аар баталсан дээрх журмыг боловсруулах нийтлэг үндэслэл болсон “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хууль⁹, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хууль¹⁰, “Цагдаагийн албаны тухай” хууль¹¹ тус тус өөрчлөгдсөн, хүчингүй болсон, шинэчлэгдэн батлагдсан тул нийтийн тээврээр хөнгөлөлттэй үйлчлүүлэгч иргэдийн бодит гүйцэтгэлийг тогтоож санхүүжилт олгох зохицуулалт бүхий шинэчилсэн журам боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах нь зүйтэй байна.

Төсөл, хөтөлбөрийн 3 арга хэмжээний зардлын батлагдсан төсвийг өссөн дүнгээр 6.6 сая төгрөгөөр хэтрүүлэн санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбар зөвлөлд дэмжлэг үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах /1.4 сая төгрөг/
- Боловсрол, эрүүл мэнд, соёл, спортын олон нийтийн арга хэмжээг жилийн турш зохион байгуулах /4.3 сая төгрөг/
- Аймгийн ИТХ-ын дэргэдэх иргэний зөвлөлийн үйл ажиллагааны зардал /0.9 сая төгрөг/

Мөн аймгийн Засаг даргын 2021 оны А/466 дугаар захирамжаар батлагдсан цэргийн жинхэнэ албаны 2021 оны хоёрдугаар ээлжийн татлага, халалтыг зохион байгуулах зардлыг анхан шатны баримтгүйгээр 0.4 сая төгрөгөөр илүү шилжүүлэн зарцуулсан, тус зардлыг онцгой комиссын зардлаас БШУГ-т олгосон санхүүжилт дээр нэмж тайлагнасан,

Аймгийн Засаг даргын 2021 оны А/54 дүгээр захирамжаар Оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах арга хэмжээнд зарцуулсан зардлаас 1.7 сая төгрөг нь анхан шатны баримтаар бүрэн дэмжигдэхгүй, тухайн арга хэмжээ нь зохион байгуулагдаагүй, санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслээгүй олгосон тул төлбөрийн акт тогтоолоо.

Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг орон нутгийн онцлогт тохирсон арга хэлбэрээр дэмжиж, төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх зардлаас Орхон аймгийн худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчийн мэдээллийн сан, гар утасны программ, 2016-2020 оны хөрөнгө оруулалтын ажлын 3-н хэмжээст цахим танилцуулга хийх 4.5 сая төгрөгийн өртөг бүхий арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, төсвийг үр ашиггүй зарцуулсан тул албан шаардлага хүргүүлээ.

Үр дүнтэй хэрэгжсэн дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрүүдийн явц, үр дүнгийн биелэлтийг жил бүр тайлагнахыг даалгасан боловч, 2020 онд хөтөлбөр тус бүрээр зорилтын хэрэгжилт, хүрсэн үр дүнг тооцож тайлагнасан байна.

⁷ Боловсролын тухай хуулийн 43.2.5-д “нийтийн тээврийн хэрэгслээр хичээлдээ явах зайлшгүй шаардлагатай сурагч, оюутны нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зардлын 50 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон журмын дагуу олгох”

⁸ Аймгийн ИТХ-ын 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрх бүхий иргэдийн нөхөн олговрыг хуваарилах, санхүүжүүлэх журам”.

⁹ Энэ хууль 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр баталсан “Ахмад настны тухай” хуулиар хүчингүй болсон.

¹⁰ Энэ хууль 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулиар хүчингүй болсон.

¹¹ Энэ хуулийг 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр баталсан “Цагдаагийн албаны тухай” хуулийн шинэчилсэн найруулгаар хүчингүй болсонд тооцсон.

Зарим дэд хөтөлбөрүүдийн үр дүнгээс дурдвал:**Хөтөлбөрийн нэр: Багш дэд хөтөлбөр**Хэрэгжүүлсэн хугацаа: **2017-2020**. /Үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй/

Хөтөлбөрийн хэрэгжилт: Хөтөлбөрийн үндсэн 3 зорилтын хүрээнд батлагдсан 23 үйл ажиллагааг 92.1 хувийн хэрэгжилттэй, үр дүнг дүгнэх 17 шалгуур үзүүлэлтийг 89.4 хувийн гүйцэтгэлтэй хангагдсанаар тайлагнасан байна. Тухайлбал: Эрүүл мэндийн үзлэгт 1737 багш, журмаар тодорхойлсон мөнгөн дэмжлэгт 259 багш, ажилтан, гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалт, туршлага судлах үйл ажиллагаанд 128 багш, ажилтан, багшийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, эрдэм, шинжилгээний хурал, илтгэлийн уралдаан зэрэг олон талт арга хэмжээнд давхардсан тоогоор 2200 гаруй багш, ажилтан хамрагджээ.

**Хөтөлбөрийн нэр: Эмч дэд хөтөлбөр**Хэрэгжүүлсэн хугацаа: **2017-2020**. /Үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй/**Хөтөлбөрийн хэрэгжилт:** 2017 оны суурь үзүүлэлттэй харьцуулахад:

- Эмч, эмнэлгийн ажилчдын төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтанд хамрагдалт 7.4 хувиар, мэргэжлийн зэрэг 22.7 хувиар, боловсролын зэрэг 5.2 хувиар тус тус өссөн, өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх, туршлага судалсан эмчийн тоо 9.0 хувиар нэмэгдсэн,
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийт 96 сувилагч, ахлах сувилагчийг ажлын байранд нь чадавхижуулж, мэргэшүүлсэн,
- Эмнэлгийн ажилчдын нийгмийн баталгааг дэмжиж нийт ажилчдын 52 хувьд буцалтгүй тусламж олгосон, урьдчилан сэргийлэх үзлэгт 100 хувь хамруулж, өвчлөл илэрсэн эмнэлгийн ажилтны 85 хувийг эмчлэн эрүүлжүүлсэн.
- Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн хангалтад 3.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

**Хөтөлбөрийн нэр: Анхдагч болон ач санах дэд хөтөлбөр**Хэрэгжүүлсэн хугацаа: **2017-2020**. /Үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй/

Хөтөлбөрийн хэрэгжилт: Анхдагч илгээлтийн эздийн нийгэмд оролцох идэвх оролцоо нэмэгдэж өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг, сургалтад хамрагдах, спортын уралдаан тэмцээн, урлаг уран сайхны үйл ажиллагаа болон дотоодын аялалд хамрагдах зэргээр давхардсан тоогоор 5600 гаруй анхдагчид хамрагдсан. Анхдагчдын холбоодыг бүртгэлжүүлж, хамтран ажиллах уялдаа холбоо сайжран, жил бүр холбоодод мөнгөн дэмжлэг үзүүлж, шаардагдах асуудлуудыг дор бүр нь шийдвэрлэдэг болсон, анхдагч-илгээлтийн эздэд үзүүлсэн үйлчилгээ, арга хэмжээний нэр төрөл нэмэгдсэн байна.

Ахмад настны Ач санах дэд хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт давхардсан тоогоор 6,000 гаруй, сургалтын үйл ажиллагаанд 3,600 гаруй, урлаг, спорт, олон нийтийн ажилд давхардсан тоогоор 19,000 гаруй ахмад оролцсон, ахмадууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, алдар гавьяагаа үнэлүүлэх зэрэг нийгмийн амьдралын оролцоо идэвх нэмэгдэж байна.

**Хөтөлбөрийн нэр: Явган зам дэд хөтөлбөр**Хэрэгжүүлсэн хугацаа: **2018-2020**. /Хэрэгжээд дууссан/

Хөтөлбөрийн хэрэгжилт: Улс, орон нутгийн төсвөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудыг дэд хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдуулан, шаардлагатай байршилд замын бүтээн байгуулалтын ажлуудыг хийж, хэрэгжүүлсэн байна.

Шинээр баригдсан орон сууцны хороолол авто зам, замын байгууламжийн зураг төсөө, төлөвлөлтөд явган хүний замыг тусган боловсруулдаг, жил бүр явган хүний замыг орон нутгийн хөрөнгө оруулалтад тусган батлагдсан жишиг зургийн дагуу хийгдэх тул “Явган зам” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн боловсруулах нь үр дүн багатай гэж үзэж дуусгасан байна.

Дэд хөтөлбөрүүдээс бусад төсөл хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнг тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тооцож батлаагүй тул нийт хөтөлбөр, арга хэмжээнд тоо, дүнгийн дийлэнх хувийг эзэлдэг энэхүү төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр дүнг тооцох боломжгүй байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан, хүрэх түвшин, дэвшүүлсэн зорилтыг тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлтээр хангасан, үр дүн гарч хангалттай үнэлэгдсэн дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Холбогдох байгууллагын санал:


**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
Цахим шуудан: info@erdenet.mn

2022.12.16 № 024/2612
танай _____-ны № _____-т

Г Г

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Орхон аймагт хэрэгжүүлж буй дэд хөтөлбөр,
төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн
аудитын тайланд өгөх санал байхгүй болно.


ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ А.ТҮВШИНЖАРГАЛ

D:/My documents/A-5 doc
61220224/2



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Уртбулаг баг, Ханддоржийн гудамж,
